



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 390

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 9 дэх заалт, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 20 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.БНХАУ-ын ӨМӨЗО-ны Дотоодыг хамгаалах тэнхим, "Хэл соёл хөгжил" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн тусламжаар олж авсан, нийт 30,942,010.28 (гучин сая есөн зуун дөчин хоёр мянга арван төгрөг хорин найман мөнгө) төгрөгийн хавсралтад заасан хөрөнгийг Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газар, Зүүн бүс дэх газрын үндсэн хөрөнгийн дансанд тус тус бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.Мөрөн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000785

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн  
390 дугаар тогтоолын хавсралт

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗАР,  
ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗРЫН БАЛАНСАД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ (төгрөг)
1.ГИХГ-ын Өмнөд бүс дэх газар					
1	Барилга (Өмнөговь аймаг, Гашуунсухайт боомт)	2011	м2	100	23,942,010.28
	Дүн				23,942,010.28
2.ГИХГ-ын Зүүн бүс дэх газар					
2	Барилга (Өмнөговь аймаг, Ульхан боомт)	2018	м2	24	7,000,000.00
	Дүн				7,000,000.00
	Нийт дүн				30,942,010.28 (гучин сая есөн зуун дөчин хоёр мянга арван төгрөг хорин найман мөнгө)